

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГСА-2023/08/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Говьсүмбэр аймаг

2023 он

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа

Утас: 70543156

Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Наранбаяр

Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn

Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн: “Ай Жэй Эй Эйч Аудит”

ХХК Захирал: Г.Энхмаа

Утас: 77450279, Цахим хаяг: ijahaudit2020@gmail.com

Аудитор: С.Сүрэнчимэг

Утас: 99067036, Цахим хаяг: surenchimeg0410@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс:976-7054 3179
И-мэйл: govisumber@audit.gov.mn

2023.02.24 № 10
танай _____-ны № _____-г

АЙМГИЙН "ХҮНС, ХӨДӨӨ АЖ
АХУЙН ГАЗАР"-ЫН ТӨСВИЙН
ЗАХИРАГЧ Н.ДАВААХҮҮ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говьсүмбэр аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус газар нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

008020039

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 11 зорилтын хүрээнд 28 хөтөлбөр, 71 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 94.3 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл /Төгрөгөөр/
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	48,601,385.50	46,329,689.25
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4,609,806.00	7,144,806.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	4,609,806.00	7,144,806.00
3121	Төгрөг	4,609,806.00	7,144,806.00
31211	Бусад төсөл, нөөцийн харилцах	4,609,806.00	7,144,806.00
34	УРЬДЧИЛГАА	7,200,000.00	0.00
34600	Урьдчилж гарсан зардал	7,200,000.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	16,786,579.50	19,179,883.25
351	Түүхий эд материал	1,700,000.00	3,182,500.00
35110	Тусгай зориулалтын материал	1,700,000.00	3,182,500.00
354	Хангамжийн материал	15,086,579.50	15,997,383.25
35410	Бичиг хэргийн материал	1,803,067.00	1,294,427.00
035420	Аж ахуйн материал	61,400.00	1,312,744.00
35440	Түлш, шатах тослох материал	345,800.00	0.00
35470	Бусад хангамжийн материал	12,876,312.50	13,390,212.25
36	НӨӨЦИЙН БАРАА	20,005,000.00	20,005,000.00
36100	Барааны нөөц	20,005,000.00	20,005,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	313,276,539.04	361,589,373.78
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	313,276,539.04	361,589,373.78
392	Биет хөрөнгө	197,085,217.22	246,337,704.63
39201	Барилга, байгууламж, орон сууц	249,617,547.00	249,617,547.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-74,495,120.10	-86,450,484.50
39203	Авто-тээврийн хэрэгсэл	113,349,280.00	69,849,280.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-113,346,280.00	-39,640,946.74
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	67,863,093.26	70,799,701.77
39206	Хуримтлагдсан элэгдэл	-57,091,959.45	-28,123,298.64
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,862,750.00	11,045,925.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,167,484.07	-6,647,750.68
39214	Бусад үндсэн хөрөнгө	30,791,940.00	15,698,820.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-24,295,549.42	-9,811,088.54
393	Биет бус хөрөнгө	116,191,321.82	115,251,669.15
39301	Программ хангамж	7,892,500.00	7,892,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-4,182,500.18	-5,122,152.85
39303	Бусад биет бус хөрөнгө	112,481,322.00	112,481,322.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	361,877,924.54	407,919,063.03
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	361,877,924.54	407,919,063.03
51	Засгийн газрын хувь оролцоо	361,877,924.54	407,919,063.03
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	437,896,678.25	437,896,678.25
512	Хуримтлагдсан үр дүн	-92,902,520.39	-113,760,410.90
51210	Өмнөх үеийн үр дүн	-77,174,774.02	-92,902,520.39
51220	Тайлант үеийн үр дүн	-15,727,746.37	-20,857,890.51
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	16,883,766.68	83,782,795.68
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	361,877,924.54	407,919,063.03

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант огноо: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	267,466,452.60	277,330,069.75
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,647,102.60	43,370,269.75
120	Нийтлэг татварын бус орлого	5,647,102.60	43,370,269.75
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	5,623,874.00	5,228,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	5,623,874.00	5,228,100.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		22,274,400.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	23,228.60	15,867,769.75
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	261,819,350.00	233,959,800.00
1310	Улсын төсвөөс	250,228,200.00	230,027,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	250,228,200.00	212,423,800.00
	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		17,604,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,591,150.00	3,932,000.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах нөөц, хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,943,150.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		3,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	648,000.00	432,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	283,194,198.97	284,750,764.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	283,194,198.97	284,750,764.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	268,483,220.53	280,918,168.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	170,119,282.00	186,788,211.46
210101	Үндсэн цалин	130,325,270.00	133,880,125.18
210102	Нэмэгдэл	26,950,894.00	31,996,028.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,294,668.00	14,988,800.12
210104	Урамшуулал	3,548,450.00	5,923,258.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,453,139.56	22,907,936.50
210201	Тэтгэврийн даатгал	15,199,377.56	15,840,147.78
210202	Тэтгэмжийн даатгал	1,673,213.00	1,866,368.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,341,766.00	1,472,934.29
210204	Ажилгүйдлийн даатгал	294,433.00	338,953.31
210205	Эрүүл мэндийн даатгал	2,944,350.00	3,389,532.97
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,785,839.00	7,184,574.46
210301	Гэрэл, цахилгаан	998,800.00	857,926.46
210302	Түлш, халаалт	4,375,600.00	5,632,098.00
210303	Цэвэр, бохир ус	411,439.00	694,550.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,774,872.60	9,938,714.00
210401	Бичиг хэрэг	3,354,753.00	2,141,740.00
210402	Тээвэр, шатахуун	11,082,800.00	4,204,660.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,130,500.00	1,029,991.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	216,000.00	216,000.00
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлс		34,500.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	9,708,519.60	2,311,823.00

210408	Бараа материал акталсны зардал	4,282,300.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,222,100.00	708,600.00
210601	Багаж, техник хэрэгсэл	0.00	218,000.00
210604	Урсгал засвар	1,222,100.00	490,600.00
2107	Томилолт, зочны зардал	837,000.00	2,611,160.00
210702	Дотоод албан томилолт	837,000.00	2,611,160.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,568,700.00	8,999,635.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,967,200.00	248,680.00
210803	Даатгалын үйлчилгээ	431,595.00	456,655.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	337,125.00	294,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	142,000.00	110,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,600,000.00	7,740,000.00
210807	Газрын төлбөр	90,780.00	150,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,722,287.37	41,779,337.26
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,862,059.00	1,380,003.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	20,860,228.37	40,399,334.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,710,978.44	3,832,595.58
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,010,000.00	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,010,000.00	1,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,700,978.44	2,832,595.58
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,700,978.44	2,832,595.58
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН(3=1-2)		-7,420,694,651
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		13,437,196.00
225	Үйл ажиллагааны бус зардал		13,437,196.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		1,261,260.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал		12,175,936.00
6	НИЙТ ҮР ДҮН (6)=(3)+(4)-(5)	-15,727,746.37	-20,857,890.51

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	495,496,678.25	16,883,766.68	-75,883,274.02	436,497,170.91
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-1,291,500.00	-1,291,500.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	495,496,678.25	16,883,766.68	--77,174,774.02	435,205,670.91
	Өмчид гарсан өөрчлөлт	-57,600,000.00			-57,600,000.00
C07	Тайлант үеийн үр дүн			-15,727,746.37	-15,727,746.37
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	437,896,678.25	16,883,766.68	-92,902,520.39	361,877,924.54
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	437,896,678.25	16,883,766.68	-92,902,520.39	361,877,924.54
	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт		66,899,029.00		66,899,029.00
D08	Тайлант үеийн үр дүн			-20,857,890.51	-20,857,890.51
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	437,896,678.25	83,782,795.68	-113,760,410.90	407,919,063.03

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
0	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	267,239,156.00	239,977,290.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,419,806.00	5,228,100.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,419,806.00	5,228,100.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	5,419,806.00	5,228,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,419,806.00	5,228,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	261,819,350.00	234,749,190.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	250,228,200.00	230,027,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	250,228,200.00	230,027,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,591,150.00	4,721,390.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах нөөц, хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,943,150.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		3,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	648,000.00	1,221,390.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	262,629,350.00	236,642,290.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	262,629,350.00	236,642,290.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	247,871,971.56	232,809,694.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	169,915,214.00	186,924,547.96
210101	Үндсэн цалин	130,121,202.00	132,959,320.05
210102	Нэмэгдэл	26,950,894.00	31,761,252.03
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,294,668.00	15,285,975.91
210104	Урамшуулал	3,548,450.00	6,917,999.97
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,453,139.56	22,771,600.00
210201	Тэтгэврийн даатгал	15,199,377.56	15,641,601.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,673,213.00	1,843,244.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,341,766.00	1,470,835.00
210204	Ажилгүйдлийн даатгал	294,433.00	346,856.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,944,350.00	3,469,064.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,785,839.00	7,184,574.46
210301	Гэрэл цахилгаан	998,800.00	857,926.46
210302	Түлш, халаалт	4,375,600.00	5,632,098.00
210303	Цэвэр, бохир ус	411,439.00	694,550.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,174,600.00	5,227,191.00
210401	Бичиг хэрэг	906,800.00	575,100.00
210402	Тээвэр, шатахуун	5,463,300.00	3,200,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,333,500.00	1,029,991.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	216,000.00	216,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,255,000.00	205,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,456,100.00	1,765,100.00

210601	Багаж техник, хэрэгсэл		975,000.00
210604	Урсгал засвар	1,456,100.00	790,100.00
2107	Томилолт, зочны зардал	837,000.00	2,611,160.00
210702	Дотоод албан томилолт	837,000.00	2,611,160.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,930,500.00	3,408,655.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,129,000.00	1,857,700.00
210803	Даатгалын үйлчилгээ	431,595.00	456,655.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	337,125.00	294,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	142,000.00	110,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,800,000.00	540,000.00
210807	Газрын төлбөр	90,780.00	150,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,319,579.00	2,916,866.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,319,579.00	2,916,866.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,757,378.44	3,832,595.58
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,056,400.00	1,000,000.00
213209	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,056,400.00	1,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,700,978.44	2,832,595.58
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,700,978.44	2,832,595.58
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	4,609,806.00	3,335,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН		<u>800,000.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		800,000.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ		800,000.00
225106	Биет ба бует бус хөрөнгө худалдан авсан зардал		800,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ(6=4+5)		<u>-800,000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	4,609,806.00	2,535,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	4,609,806.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,609,806.00	7,144,806.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	230,027,800.00	228,212,694.42	-1,815,105.58	99.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	230,027,800.00	228,212,694.42	-1,815,105.58	99.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	229,013,400.00	227,212,694.42	-1,800,705.58	99.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	187,206,200.00	186,924,547.96	-281,652.04	99.8
210101	Үндсэн цалин	143,001,400.00	132,959,320.05	-10,042,079.95	93.0
210102	Нэмэгдэл	39,364,800.00	31,761,252.03	-7,603,547.97	80.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,840,000.00	15,285,975.91	10,445,975.91	315.8
210104	Урамшуулал	0.0	6,917,999.97	6,917,999.97	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,400,700.00	22,771,600.00	-629,100.00	97.3
210201	Тэтгэврийн даатгал	15,912,500.00	15,641,601.00	-270,899.00	98.3
210202	Тэтгэмжийн даатгал	1,872,100.00	1,843,244.00	-28,856.00	98.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,497,600.00	1,470,835.00	-26,765.00	98.2
210204	Ажилгүйдлийн даатгал	374,400.00	346,856.00	--27,544.00	92.6
210205	Эрүүл мэндийн даатгал	3,744,100.00	3,469,064.00	-275,036.00	92.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,028,200.00	7,184,574.46	-843,625.54	89.5
210301	Гэрэл, цахилгаан	882,800.00	857,926.46	-24,873.54	97.2
210302	Түлш, халаалт	6,425,300.00	5,632,098.00	-793,202.00	87.7
210303	Цэвэр, бохир ус	720,100.00	694,550.00	-25,550.00	96.5
2104	Хангамж, бараа материалын зардал	3,753,500.00	3,727,191.00	-26,309.00	99.3
210401	Бичиг хэрэг	495,100.00	575,100.00	-80,000.00	116.2
210402	Тээвэр, шатахуун	1,700,600.00	1,700,600.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,136,300.00	1,029,991.00	-106,309.00	90.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	216,000.00	216,000.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	205,500.00	205,500.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,591,100.00	1,591,100.00	0.00	100.0
210601	Багаж, техник хэрэгсэл	975,000.00	975,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	616,100.00	616,100.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	362,500.00	353,160.00	-9,340.00	97.4
210702	Дотоод албан томилолт	362,500.00	353,160.00	-9,340.00	97.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,219,200.00	4,208,655.00	--10,545.00	99.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,657,700.00	2,657,700.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	467,200.00	456,655.00	-10,545.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	294,200.00	294,200.00	0.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	110,000.00	0.00	100.0
210807	Газрын төлбөр	150,100.00	150,100.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	452,000.00	451,866.00	-134.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	452,000.00	451,866.00	-134.00	100.0

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	600,000	1,733,800.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,014,400.00	1,000,000.00	-14,400.00	98.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,014,400.00	1,000,000.00	-14,400.00	98.6
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,014,400.00	1,000,000.00	-14,400.00	98.6
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	230,027,800.00	228,440,794.42	-1,815,105.58	99.2
1320	Улсын төсвөөс санхүүжих	230,027,800.00	228,212,694.42	-1,815,105.58	99.2
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	230,027,800.00	228,212,694.42	-1,815,105.58	99.2
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	228,100.00	228,100.00	99.2

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	/төгрөгөөр/ Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,721,390.00
УРСГАЛ ЗАРДАЛ	4,721,390.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,932,000.00
Хангамж, бараа материалын зардал	1,500,000.00
Тээвэр, шатахуун	1,500,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	174,000.00
Урсгал засвар	174,000.00
Томилолт, зочны зардал	2,258,000.00
Дотоод албан томилолт	2,258,000.00
Урсгал шилжүүлэг	789,390.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	789,390.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	789,390.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,721,390.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,721,390.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	4,721,390.00
Дээд шатны захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,500,000.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,221,390.00

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 1 зөрчил¹ илэрч 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт тогтоогоогүй

5.2 Албан шаардлага өгөөгүй

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Цалин хөлс болон нэмэгдэл урамшил бүлгийн дүнгээр 187,206.2 мянган төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 186,924.5 мянган төгрөг гарч 281.6 мянган төгрөгөөр хэмнэсэн боловч урамшууллын зардалд батлагдсан төсөв байхгүй байхад 6,918.0 мянган төгрөг зарцуулсан, мөн унаа хоолны хөнгөлөлт 4,840.0 төгрөгийн төсөв батлагдсанаас 15,286.0 мянган төгрөг зарцуулж, 10,446.0 мянган төгрөгөөр батлагдсан төсвийг хэтрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2 "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ"; 41.2.2 "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Төсвийг үндэслэлтэй боловсруулж, холбогдох газарт уламжлан батлуулах, цаашид батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 5 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Урамшууллын зардалд батлагдсан төсөвгүй байхад зардал гаргасан.	1	0.0					1	0.0				
Бичиг хэргийн зардал төлөвлөснөөс 80.0 мянган төгрөгөөр буюу 16.1 хувиар хэтэрсэн байна.	1	80.0					1	80.0				
Дүн	2	80.0					1	80.0				